



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт.....	19
Байхгүй	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.ХОНЫРАТ ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒5 № ᠒55
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,827,123.00</u>	<u>22,801,754.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,700,309.00	45,210.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,700,309.00	45,210.00
3121	Төгрөг	1,700,309.00	45,210.00
31211	Төрийн сангийн харилцах	-	45,210.00
31213	Арилжааны банк дахь харилцах	1,700,309.00	
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	926,814.00	1,804,544.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	926,814.00	1,804,544.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	20,200,000.00	20,952,000.00
354	Хангамжийн материал	10,300,000.00	11,052,000.00
35410	Бичиг хэргийн материал	-	-
35420	Аж ахуйн материал	10,300,000.00	11,052,000.00
35600	Мал амьтад	9,900,000.00	9,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,471,420,365.07</u>	<u>4,429,630,215.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,471,420,365.07	4,429,630,215.61
392	Биет хөрөнгө	4,468,096,365.07	4,426,306,215.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,235,477,585.30	3,266,445,365.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(484,944,093.77)	(573,031,568.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	171,787,889.00	225,001,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(120,808,440.42)	(132,988,702.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,598,885.00	54,944,915.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(62,735,884.92)	(36,234,498.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,459,255.00	11,375,721.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,964,066.80)	(7,590,992.93)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,658,510,375.00	1,658,510,375.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(25,285,138.32)	(50,570,276.64)
393	Биет бус хөрөнгө	3,324,000.00	3,324,000.00
39301	Програм хангамж	2,113,400.00	536,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,113,400.00)	(536,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,324,000.00	3,324,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,494,247,488.07</u>	<u>4,452,431,969.61</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,860,742.00</u>	<u>6,295,234.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,860,742.00	6,295,234.00
413	Өглөг	10,860,742.00	6,295,234.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	10,860,742.00	6,295,234.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,870,742.00	6,295,234.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,990,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,483,386,746.07</u>	<u>4,446,136,735.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,483,386,746.07	4,446,136,735.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,795,227,276.32	1,795,227,276.32
51101	Өмч: - төрийн	1,795,227,276.32	1,795,227,276.32
512	Хуримтлагдсан үр дүн	1,359,590,822.90	1,322,361,915.44
51210	Өмнөх үеийн үр дүн	1,423,248,869.71	1,359,611,925.90
51220	Тайлант үеийн үр дүн	(63,658,046.81)	(37,250,010.46)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,328,568,646.85	1,328,547,543.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,494,247,488.07</u>	<u>4,452,431,969.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	631,249,337.43	663,556,730.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,658,235.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	25,658,235.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	25,658,235.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,518,235.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	605,591,102.43	663,556,730.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131005	Хөрөнгийн санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,969,244.00	90,750,975.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,909,960.00	1,607,175.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,753,494.00	89,143,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	305,790.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	590,621,858.43	572,805,755.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	590,621,858.43	483,592,210.00

132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/		89,213,545.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	694,907,384.24	695,746,689.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	694,907,384.24	695,746,689.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	692,806,586.24	671,835,289.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,141,778.00	309,139,594.50
210101	Үндсэн цалин	296,506,811.00	307,639,594.50
210102	Нэмэгдэл	19,168,990.00	-
210104	Урамшуулал	-	1,500,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,465,977.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,966,367.00	40,173,960.50
210201	Тэтгэврийн даатгал	33,542,267.00	27,836,541.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,105,900.00	3,075,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,484,800.00	2,460,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	621,300.00	343,918.66
210205	Эрүүл мэндийн даатгал	6,212,100.00	6,458,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,870,297.43	24,702,634.00
210301	Гэрэл, цахилгаан	1,932,600.00	2,378,400.00
210302	Түлш, халаалт	24,937,697.43	22,324,234.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,709,264.00	33,814,757.00
210401	Бичиг хэрэг	4,039,150.00	6,833,250.00
210402	Тээвэр, шатахуун	33,395,714.00	21,321,007.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,234,400.00	5,572,800.00
210404	Ном, хэвлэл	40,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	87,700.00
2105	Нормативт зардал	2,414,500.00	417,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,414,500.00	417,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,879,364.00	878,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	405,700.00	
210604	Урсгал засвар	21,473,664.00	878,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,854,448.00	555,500.00
210702	Дотоод албан томилолт	1,854,448.00	555,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,065,079.00	1,711,718.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,183,079.00	877,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	352,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,900.00	185,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	144,000.00
210807	Газрын төлбөр	-	37,218.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,905,488.81	260,442,025.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,579,802.00	125,680,602.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	70,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,325,686.81	134,691,423.53
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,100,798.00	23,911,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,100,798.00	23,911,400.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,100,798.00	23,911,400.00
213404	Хөрөнгийн	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(63,658,046.81)	(32,189,959.53)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,060,050.93
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,060,050.93
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(5,060,050.93)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(63,658,046.81)	(37,250,010.46)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,795,227,276.32	1,328,568,646.85	1,359,590,822.90	4,483,386,746.07
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,795,227,276.32	1,328,568,646.85	1,359,590,822.90	4,483,386,746.07
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,795,227,276.32	1,328,568,646.85	1,359,590,822.90	4,483,386,746.07
D01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,795,227,276.32	1,328,568,646.85	1,359,590,822.90	4,483,386,746.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			21,103.00	21,103.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,795,227,276.32	1,328,568,646.85	1,359,611,925.90	4,483,407,849.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(21,103.00)		(21,103.00)
D08	Тайлант үеийн үр дүн			(37,250,010.46)	(37,250,010.46)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,795,227,276.32	1,328,547,543.85	1,322,361,915.44	4,446,136,735.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>605,731,102.43</u>	<u>574,343,185.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	140,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	605,591,102.43	574,343,185.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,969,244.00	90,750,975.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,909,960.00	1,607,175.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,753,494.00	89,143,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	305,790.00	
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	590,621,858.43	483,592,210.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	590,621,858.43	483,592,210.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>557,645,793.43</u>	<u>567,250,504.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	557,645,793.43	567,250,504.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,544,995.43	543,339,104.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,033,292.00	311,738,709.00
210101	Үндсэн цалин	252,088,015.00	227,095,175.00
210102	Нэмэгдэл	61,991,982.00	64,855,608.00
210104	Урамшуулал		1,500,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,953,295.00	18,287,926.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,704,000.00	38,304,300.00
210201	Тэтгэврийн даатгал	33,279,900.00	26,003,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,105,900.00	3,075,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,484,800.00	2,460,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	621,300.00	615,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,212,100.00	6,150,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,792,121.43	18,469,400.00

210301	Гэрэл, цахилгаан	1,870,600.00	2,440,400.00
210302	Түлш, халаалт	21,921,521.43	16,029,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,602,804.00	31,986,600.00
210401	Бичиг хэрэг	3,441,000.00	6,322,000.00
210402	Тээвэр, шатахуун	29,927,404.00	20,003,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,234,400.00	5,572,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		88,000.00
2105	Нормативт зардал	381,500.00	457,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	381,500.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,321,064.00	2,989,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	13,321,064.00	2,989,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,854,448.00	555,500.00
210702	Дотоод албан томилолт	1,854,448.00	555,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,962,746.00	3,341,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,080,746.00	1,915,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	352,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,900.00	185,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	398,700.00
210807	Газрын төлбөр		289,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		85,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,893,020.00	135,496,895.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,893,020.00	134,996,895.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,100,798.00	23,911,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	23,911,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		23,911,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,100,798.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,100,798.00	
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>48,085,309.00</u>	<u>7,092,681.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	46,385,000.00	8,747,780.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,385,000.00	8,747,780.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,385,000.00	8,747,780.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,385,000.00	8,747,780.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(46,385,000.00)</u>	<u>(8,747,780.00)</u>
14	Бусад эх үүсвэр	-	-
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,700,309.00	(1,655,099.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,700,309.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,700,309.00	45,210.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	483,547,000.00	485,247,309.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	483,547,000.00	485,247,309.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	459,635,600.00	461,335,909.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,038,400.00	311,738,709.00
210101	Үндсэн цалин	231,496,400.00	227,095,175.00
210102	Нэмэгдэл	59,864,800.00	64,855,608.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,677,200.00	18,287,926.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,304,300.00	38,304,300.00
210201	Тэтгэврийн даатгал	26,003,500.00	26,003,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,075,200.00	3,075,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,460,100.00	2,460,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	615,100.00	615,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,150,400.00	6,150,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,469,400.00	18,469,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,440,400.00	2,440,400.00
210302	Түлш, халаалт	16,029,000.00	16,029,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,636,600.00	30,636,600.00
210401	Бичиг хэрэг	6,322,000.00	6,322,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,653,800.00	18,653,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,572,800.00	5,572,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,989,400.00	2,989,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	2,989,400.00	2,989,400.00
2107	Томилолт, зочны зардал	555,500.00	555,500.00
210702	Дотоод албан томилолт	555,500.00	555,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,341,300.00	3,341,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,915,200.00	1,915,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,700.00	185,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,700.00	398,700.00
210807	Газрын төлбөр	289,200.00	289,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	85,000.00	85,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,843,700.00	54,843,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,343,700.00	54,343,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,911,400.00	23,911,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,911,400.00	23,911,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,911,400.00	23,911,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	483,547,000.00	483,592,210.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	483,547,000.00	483,592,210.00
132001	Орон нутгийн төсвөөс	483,547,000.00	483,592,210.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,700,309.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		45,210.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	33
620001	Удирдах ажилтан	14	14
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	4	5
620004	Гэрээт ажилтан	4	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31	33

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	16
650010	Гэрээт ажилтан	4	6
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,969,244.00	90,750,975.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,969,244.00	90,750,975.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,398,972.00	90,750,975.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,439,504.00	1,350,000.00
210401	Бичиг хэрэг	195,000.00	
210402	Тээвэр, шатахуун	944,504.00	1,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	
2107	Томилолт, зочны зардал	937,948.00	-
210702	Дотоод албан томилолт	937,948.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,021,520.00	89,400,975.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,021,520.00	89,400,975.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,570,272.00	-
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,570,272.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,969,244.00	90,750,975.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,969,244.00	90,750,975.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,909,960.00	1,607,175.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,753,494.00	89,143,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	305,790.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №3/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Улаанхус сумын Засаг даргын тамгын газар нь: Сумын иргэдийн нийтлэг эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээн, эрх чөлөөт, ажил орлоготой иргэд бүхий байгальд ээлтэй үйлдвэрлэл, ногоон эдийн засагтай аялал жуулчлалаар бүсдээ тэргүүлсэн жишиг сум болоход зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус газарт дотоод аудитор ажилладаггүй, тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас шалгалт хийгдэж, 4.4 сая төгрөгийн акт тогтоосныг барагдуулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 694.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41.8 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт:

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,700.3	45.2	(1,655.1)
Авлага	926.8	1,804.5	877.7
Урьдчилгаа			-
Бараа материал	20,200.0	20,952.0	752.0
Үндсэн хөрөнгө	4,471,420.3	4,429,630.2	(41,790.1)
Нийт хөрөнгө	4,494,247.4	4,452,431.9	(41,815.5)
Өр төлбөр	10,860.7	6,295.2	(4,565.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,483,386.7	4,446,136.7	(37,250.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,494,247.4	4,452,431.9	(41,815.5)

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдлийг зарцуулж, оны эцэст 0.04 сая төгрөгийн үлдэгдэлтэй, авлага дансны оны эхний үлдэгдлийг барагдуулж, оны эцэст шинээр 1.5 сая

төгрөгийн цалингийн урьдчилгаа, 0.2 сая төгрөгийн НДШ-ийн, 0.08 сая төгрөгийн цалингийн ашгийн, нийт 1.8 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20.9 төгрөг болж 0.7 сая төгрөгөөр өсөж, тайлант онд 37.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 36.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4429.6 сая төгрөг болж 41.8 сая төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, акталсан хөрөнгийн зөрүүгээр буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, сумын ОНХС-гаас 36.0 сая, сумын ЭМТ-өөс 53.2 сая төгрөгийн үлдэх өртөгтэй автомашиныг балансаас балансад шилжүүлэн авч, нийт 97.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, сумын Цагдаагийн хэсгийн 1.6 сая төгрөгийн машиныг аймгийн Цагдаагийн газрын балансад шилжүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 тоот тогтоолоор 43.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан байна.

Өр төлбөр дансны оны эхний 10.9 сая төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулж, оны эцэст шинээр 6.3 сая төгрөгийн түлш халаалтын өглөгтэй гарсан байна. Энэ нь халаалтын зардлын төсөв дутуу батлагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансанд өөрчлөлт гараагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 663.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 32.3 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн санхүүжилт байна. Нийт зардал өмнөх оноос 0.8 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын 0.02 сая төгрөгийн акталсан хөрөнгө холбоотой өөрчлөлт гарсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны ээлжит II хуралдааны 16 дугаар тогтоолоор тус газрын төсвийг орон нутгийн төсвөөс 406.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны Төсвийн сарын зохицуулсан хуваарь батлах тухай А/1093 тоот захирамжаар тус газрын батлагдсан төсвийг 483.5 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Энэ нь анх батлагдсан төсвөөс томилолтын зардлаас 2.4 сая төгрөгөөр бууруулж, цалин зардлыг 0.3 сая, гэрэл цахилгаан 1.1 сая, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо 16.3 сая, урсгал засвар 1.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 2.0 сая, бараа үйлчилгээний бусад зардал 52.3 сая, тэтгэвэр тэтгэмжийн зардал 3.0 сая, нийтдээ

76.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Нэмэгдсэн зардлын ихэнхийг орон нутгийн орлогын давсан хэсгээс санхүүжүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 483.5 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 485.2 сая төгрөг төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаанд зарцуулж, оны эхний үлдэгдлээс 1.7 сая төгрөгийн зарцуулсан байна. Оны эцэст төсвийн харилцах дансанд 0.04 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч эхний үлдэгдлээс зарцуулсан хэмжээгээр хэтрэлттэй гарсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээ, батлагдсан төсөв гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Арга хэмжээ	Нэршил	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	70106	70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага			
2		80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	293849.0	293894.2	-45.2
3		80102	Туслах үйл ажиллагааны зардал	132342.9	132342.9	-
4		80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	23911.4	23911.4	-
5		81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	33443.7	33443.7	-
Нийт дүн				483547.0	483592.2	-45.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 90.7 төгрөгийн санхүүжилт хүлээн авчээ. Статистикийн хэлтсээс мал тооллогын зардал, судалгааны зардлаас 1.6 сая, аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 44.6 сая, аймгийн ОНХС-гаас 1.0 сая, аймгийн ИТХ-аас ГХУС зардал 0.3 сая, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын зардлаас 0.1 сая төгрөгийг, “Сайхан монголын өнгө” ТББ-аас Хөх хөтөл багийн хогийн цэгийн автомашин, тракторын үнэ 42.0 сая, бусад эх үүсвэрээс 1.2 сая төгрөгийг, нийт 90.8 сая төгрөгийг бүрдүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийг 1 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээний зардалд 1.4 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 89.4 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардлуудад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 310.0 сая төгрөг, НДШ-ийн зардалд 38.3 сая төгрөг, тогтмол зардалд 18.5 сая төгрөг, шатахууны зардалд 18.6 сая төгрөг, тэтгэмжийн зардалд 23.9 сая нийтдээ 409.3 сая төгрөг зарцуулахаар батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 485.3 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 409.3 сая төгрөгийг хасахад 76.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 2021 онд төсвөөс 7.0 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллахаар тооцоо гарч байна.

Өмнөх онд бараа үйлчилгээний зардал дутуу батлагдсантай холбоотой 10.9 сая төгрөгийн өглөгийг төсвийн хэмнэлттэй гарсан зардлаас гүйлгэн зарцуулах эрх авч бүрэн барагдуулж ажилласнаар төсөв хэмнэх боломж гараагүй байна.

Улаанхус сумын Засаг даргын тамгын газар тайлант онд халаалтын зардалд батлагдсан 16.0 сая төгрөгийг бүрэн төлсөн боловч оны эцэст шинээр 6.3 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Энэ нь халаалтын зардлын төсвийг газрын төсөвт дутуу суулгасан, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанхус сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 648.7 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 648.7 сая төгрөгийн 116 мэдээллийг ил тод байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 заалттай зөвлөмж өгөгдснийг биелүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй, санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул төсвийн зарцуулалтыг бүрэн үзэх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

